

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ
ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ БОЛОН УЛС ХООРОНД ҮРЧЛЭХ АСУУДЛААР ХАМТРАН
АЖИЛЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1995 оны 5 дугаар сарын 1-нд хүчин
төгөлдөр болсон*

Энэхүү Конвенцид гарын үсэг зурсан улсууд,
хүүхдийг өв тэгш хөгжүүлэх үүднээс тэднийг
гэр бүлийн болон баяр баясгалан, хайр,
ойлголцлын орчинд өсгөн хүмүүжүүлэхийг
хүлээн зөвшөөрч,

улс бүр хүүхдийг төрсөн гэр бүлийн
халамжинд байлгах зохистой арга хэмжээ
тэргүүн ээлжинд авч хэрэгжүүлэхийг уриалж,
төрөлх улсад үрчлэн авах тохиромжтой гэр
бүл олдохгүй тохиолдолд хүүхдийг улс
хооронд үрчлэх нь байнгын гэр бүлийн
харгалзан үзсэнээр үрчлүүлж буй хүүхдэд
тааламжтай байдал олгохыг хүлээн
зөвшөөрч,

улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд
ашиг сонирхолд нийцүүлэн, үндсэн эрхийг нь
хүндэтгэж, хүүхэд худалдах, хулгайлах, хил
дамнан худалдахаас сэргийлэх арга хэмжээ
авах шаардлагатайг ухамсарлаж,

олон улсын баримт бичгүүдэд тусгагдсан
зарчмууд, тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай
1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн
Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенц,
мөн Хүүхэд хамгаалал, хүүхдийн аж
байдлын талаар үндэсний болон улс
хооронд хүүхдийг асрамжид шилжүүлэх
нийгмийн болон эрх зүйн зарчмуудын тухай
Нэгдсэн Үндэстний Байгууллагын тунхаглал
(Ерөнхий Ассамблейн 1986 оны 12 дугаар
сарын 3-ны өдрийн 41/85 тоот тогтоол)-ыг
харгалзан үзэж нийтлэг ойлголт тогтоохыг
эрмэлзэн,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов:

I ХЭСЭГ

КОНВЕНЦИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

1 дүгээр зүйл

Энэхүү Конвенцийн зорилго нь:



(а) улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхол болон түүний үндсэн эрх олон улсын эрх зүйд нийцэж байгаа талаар баталгаа бүрдүүлэх;

(b) хүүхэд хулгайлах, худалдах, хил дамнан худалдахаас сэргийлж тэдгээр баталгааг хүндэтгэх үүднээс хэлэлцэн тохирогч улсууд хамтын ажиллагааны тогтолцоо бий болгох;

(c) Хэлэлцэн тохирогч улсууд Конвенцийн дагуу хүүхэд үрчлэхийг зөвшөөрөх явдлыг хангахад оршино.

2 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг улсад ("төрөлх улс")/ оршин суугаа, хүлээн авах улсын оршин суугч этгээд буюу төрөлх улсад байгаа гэрлэгчид үрчлэн авсны дараа бусад хүлээн авагч улсад буюу төрөлх улсын дотор ийнхүү үрчлүүлэх зорилгоор хэлэлцэн тохирогч өөр нэг улсад ("хүлээн авагч улс") хүүхэд шилжин очсон, очих гэж байгаа буюу очиход энэхүү Конвенц үйлчилнэ.

2. Энэхүү Конвенц нь зөвхөн эцэг эх хүүхдийн байнгын харилцаа бий болгох үрчлэлтэд хамаарна.

3 дугаар зүйл

Хүүхдийг арван найман нас хүрэхээс өмнө 17 дугаар зүйлийн (c) дэд хэсэгт заасан хэлэлцээ хийгээгүй бол Конвенц үйлчлэхгүй.

II ХЭСЭГ

УЛС ХООРОНД ХҮҮХЭД ҮРЧЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4 дүгээр зүйл

Конвенцийн хамрах хүрээний дагуу хүүхдийг үрчлэхэд төрөлх улсын эрх бүхий байгууллага:

(а) хүүхдийг үрчлүүлж болохыг тогтоосон;

(b) хүүхдийг асрамж хамгаалалтад шилжүүлэх боломжийг төрөлх улсад судалсны үндсэн дээр улс хооронд үрчлэх нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэхийг тогтоосон;

(c) дараахь шаардлагыг хангасан. Үүнд:

(1) Хүүхэд үрчлэлтэд шаардагдах хувь этгээд, албан газар, эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн үр дагаврын тухай, түүнчлэн хүүхэд болон түүний төрсөн гэр бүлийн



хоорондын эрх зүйн харилцаа дуусгавар болох эсэх талаар мэдээлэл авах;

(2) тэдгээр хувь этгээд, албан газар, эрх бүхий байгууллага зөвшөөрлөө сайн дураар, хуульд заасан хэлбэрээр бичгээр гэрчлэх буюу илэрхийлэх;

(3) зөвшөөрлийг аливаа төрлийн төлбөр, нөхөн төлбөрт үндэслэж олгоогүй бөгөөд түүнийгээ буцааж аваагүй;

(4) шаардлагатай тохиолдолд эхийн зөвшөөрлийг зөвхөн хүүхэд төрсний дараа авах;

(d) хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан доорх зүйлийг хангасан байна:

(1) хүүхдэд зөвлөгөө өгсөн болон үрчлэх талаар түүнд зохих мэдээлэл өгсөн бөгөөд хэрэв шаардлагатай бол үрчлэн авах тухай түүнээс зөвшөөрөл авах;

(2) хүүхдийн хүсэл, бодлыг анхаарч үзсэн байх;

(3) хэрэв шаардлагатай бол хүүхдээс үрчлэх зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөл нь сайн дураар, хуульд заасан хэлбэр болох бичгээр гэрчлүүлэх буюу илэрхийлэх;

(4) ийм зөвшөөрлийг аливаа төрлийн төлбөр, нөхөн төлбөрийн үндсэн дээр олгохгүй байх.

5 дугаар зүйл

Конвенцийн хамрах хүрээний дагуу хүүхдийг үрчлүүлэхэд хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага:

(a) үрчлэн авах гэж буй эцэг эх нь үрчлэх эрхтэй буюу боломжтой гэж тогтоогдсон;

(b) үрчлэн авах гэж буй эцэг эхэд шаардлагатай зөвлөгөө өгсөн байх;

(c) хүүхэд тэрхүү улсад байнга оршин суух, эсхүл нэвтрэх зөвшөөрөлтэй гэдэг нь тогтоогдсон;

III ХЭСЭГ

ЭРХ БҮХИЙ ТӨВ БАЙГУУЛЛАГА БОЛОН
ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

6 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч улс бүр Конвенцоор хүлээсэн үүргийг гүйцэтгэх эрх бүхий төв байгууллагыг томилон ажиллуулна.

2. Холбооны улс, нэгээс дээш эрх зүйн тогтолцоотой улс, эсхүл бие даасан нутаг



дэвсгэрийн нэгж бүхий улсууд нэгээс дээш төв байгууллагыг томилон ажиллуулах эрхтэй бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа явагдах газар нутаг дэвсгэр, хамрах хүрээг тодорхойлно. Нэгээс дээш эрх бүхий төв байгууллагыг томилсон улс тухайн улсын зохих төв байгууллагаар дамжуулан харилцах эрх бүхий нэг төв байгууллагыг томилно.

7 дугаар зүйл

1. Хүүхдийг хамгаалах болон Конвенцийн бусад зорилгыг биелүүлэхийн тулд төв байгууллагууд хамтран ажиллаж, улсынхаа эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.

2. Тэдгээр нь доорх асуудлаар холбогдох арга хэмжээг авна:

(а) үрчлэлтийн талаархи өөрийн улсын хууль тогтоомж, статистик, стандартын хэлбэр зэрэг бусад ерөнхий мэдээллээр хангах;

(б) Конвенцийн хэрэгжилтийн талаар харилцан мэдээлэл солилцох, түүний хэрэгжилтэд учирч байгаа саад бэрхшээлийг арилгах.

8 дугаар зүйл

Эрх бүхий төв байгууллагууд шууд буюу төрийн байгууллагаар дамжуулан үрчлэлттэй холбогдуулан зүй бус санхүүгийн буюу бусад ашиг хонжоо олох явдлаас сэргийлэх, Конвенцийн зорилтод харшлах бүх үйлдлийг таслан зогсоох зохистой арга хэмжээг авна.

9 дүгээр зүйл

Эрх бүхий төв байгууллагууд өөрсдөө буюу тухайн улсад зохих журмын дагуу итгэмжлэгдсэн болон төрийн байгууллагаар шууд дамжуулан доорх асуудлаар холбогдох бүх арга хэмжээг авна:

(а) хүүхэд үрчлэн авах явцыг эцэслэн баримтжуулах зорилгоор үрчлэн авах эцэг эхийн болон хүүхдийн байдалтай холбогдох мэдээлэл цуглуулах, хадгалах, солилцох;

(б) хүүхэд үрчлэх явцыг дэмжин туслах, хянах, түргэтгэх;

(с) өөрийн улсад үрчлэлттэй холбогдсон асуудлаар зөвлөгөө өгөх болон үрчилж



авсны дараахь үйлчилгээг өргөжүүлэх;
(d) улс хооронд хүүхэд үрчлүүлэхтэй холбогдсон туршлагын талаархи ерөнхий тайланг харилцан солилцох;
(e) бусад эрх бүхий төв байгууллагууд, төрийн байгууллагуудаас тодорхой нэг үрчлэлттэй холбоотой асуудлаар мэдээлэл авахаар үндэслэлтэй хүсэлт гаргавал өөрийн улсын хуулиар зөвшөөрсөн хэмжээнд хариулт өгөх.

10 дугаар зүйл

Итгэн хүлээлгэсэн үүрэг, даалгаврыг зохистой гүйцэтгэх чадвар бүхий байгууллагад итгэмжлэл олгон ажиллуулна.

11 дүгээр зүйл

Итгэмжлэгдсэн байгууллага нь:

(a) итгэмжлэл олгосон улсын эрх бүхий байгууллагаас тогтоосон нөхцлийн хүрээнд ашгийн бус үйл ажиллагаа явуулна;

(b) улс хооронд хүүхэд үрчлүүлэх ажлын туршлагатай, ёс суртахуун болон сургалтын шалгуурыг хангасан хүмүүсээр удирдуулан ажиллуулах;

(c) тухайн улсын эрх бүхий байгууллага өөрийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа болон санхүүгийн байдлыг хянах.

12 дугаар зүйл

Хоёр улсын эрх бүхий байгууллага зөвшөөрсөн бол хэлэлцэн тохирогч нэг улсад итгэмжлэгдсэн байгууллага хэлэлцэн тохирогч нөгөө улсад үйл ажиллагаа явуулж болно.

13 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч улс эрх бүхий төв байгууллагуудыг томилсон тухай, түүнчлэн тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээ болон итгэмжлэгдсэн байгууллагын нэр, хаягийг олон улсын хувийн эрх зүйн асуудлаар байгуулагдсан Гаагийн бага хурлын байнгын товчоонд мэдэгдэнэ.

IV ХЭСЭГ

УЛС ХООРОНД ҮРЧЛЭХ ЯВЦАД ТАВИГДАХ
ШААРДЛАГА

14 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч улс нэг улсад байнга оршин суугаа этгээд хэлэлцэн тохирогч

нөгөө улсад байнга оршин суугаа хүүхдийг үрчлэн авахыг хүсвэл байнга оршин суудаг улсынхаа эрх бүхий төв байгууллагад хандана.

15 дугаар зүйл

1. Хүсэлт гаргасан этгээд хүүхэд үрчлэн авах боломжтой гэж үзвэл тэдний хувийн шинж, үрчлүүлэхэд тохиромжтой эсэх болон боловсрол, гэр бүлийн болон эрүүл мэнд, өвчний түүх, нийгмийн байдал, үрчлэн авах болсон шалтгаан, улс хооронд хүүхэд үрчлэн авах чадвар болон тэдний асрамжинд очих хүүхдийн байдал зэрэг мэдээлэл агуулсан тайланг хүлээн авагч улсын эрх бүхий төв байгууллага бэлтгэнэ.

2. Тэрбээр тайландаа тухайн хүүхдийн төрөлх улсын эрх бүхий төв байгууллагад хүргүүлнэ.

16 дугаар зүйл

1. Хэрэв хүүхдийн төрөлх улсын эрх бүхий төв байгууллага уг хүүхдийг үрчлэх бүрэн боломжтой гэж үзвэл:

(а) хүүхдийн хувийн шинж, үрчлүүлэх боломж, намтар, нийгмийн байдал, гэр бүлийн түүх, өөрийн буюу гэр бүлийн эрүүл мэнд, өвчний түүх болон хүүхдийн онцгой хэрэгцээний талаархи мэдээллийг агуулсан тайлан бэлтгэнэ;

(b) хүүхдийн хүмүүжил, гарал угсаа, шашин шүтлэг, соёлын болон орчны байдалд зохих анхаарал хандуулна;

(c) зөвшөөрлийг 4 дүгээр зүйлийн дагуу олгосон эсэхийг тодруулна;

(d) хүүхэд болон үрчлэн авах эцэг, эхийн талаархи тайланг үндэслэн төлөвлөж буй үрчлэлт хүүхдийн ашиг сонирхолд нийцэж буй эсэхийг тодорхойлно.

2. Тэрбээр, хүлээн авагч улсын эрх бүхий төв байгууллагад хүүхдийн талаархи тайлан, шаардлагатай зөвшөөрлийг авсан тухай нотолгоо болон үрчлүүлэх тухай шийдвэр гаргах болсон шалтгааныг хүргүүлнэ, чингэхдээ эх оронд нь задрааж болохгүй эцэг эхийн талаархи мэдээллийг задраахгүй байхад анхаарна.

17 дугаар зүйл



Хүүхдийг үрчлэн авах эцэг эхэд нь даалган хүлээлгэж өгөх шийдвэрийг хүүхдийн төрөлх улсад зөвхөн доорх тохиолдолд гаргана:

(а) тухайн улсын эрх бүхий төв байгууллага үрчлэн авах гэж буй эцэг эхийн зөвшөөрлийг баталгаажуулсан;

(b) хүлээн авагч улсын эрх бүхий төв байгууллага буюу тус улсын хуулиар болон төрөлх улсын эрх бүхий төв байгууллага тийм шийдвэрийг зөвшөөрсөн;

(c) хоёр улсын эрх бүхий төв байгууллага үрчлэлтийн явцыг үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн;

(d) 5 дугаар зүйлийн дагуу үрчлэн авах эцэг эх нь үрчлэн авах боломжтой бөгөөд хүүхэд хүлээн авагч улсад байнга оршин суух зөвшөөрөлтэй, эсхүл нэвтрэх зөвшөөрөлтэй гэдэг нь тогтоогдсон.

18 дугаар зүйл

Хоёр улсын эрх бүхий төв байгууллага нь хүүхдийн төрөлх улсаас гарч явах, хүлээн авагч улсад нэвтэрч, байнга оршин суух зөвшөөрлийг авахад шаардлагатай бүх арга хэмжээг авна.

19 дүгээр зүйл

1. 17 дугаар зүйлийн шаардлагыг хангасан тохиолдолд хүүхдийг хүлээн авагч улсад шилжүүлнэ.

2. Хоёр улсын эрх бүхий төв байгууллагууд хүүхдийг баталгаатай, зөв зохистой нөхцөлд шилжүүлэх бүхий л бололцоогоор хангах бөгөөд боломжтой тохиолдолд үрчлэн авах, эцэг эхийг дагалдуулан явуулна.

3. Хүүхдийг шилжүүлээгүй тохиолдолд 15, 16 дугаар зүйлд тусгагдсан тайлан илгээсэн эрх бүхий байгууллагад буцаана.

20 дугаар зүйл

Хэрэв туршилтын хугацаа шаардлагатай бол эрх бүхий төв байгууллагууд үрчлэлтийн явцыг эцэслэн дуусгахаар авсан арга хэмжээ, шилжүүлэн суурьшуулах явцын талаар бие биендээ мэдээлнэ.

21 дүгээр зүйл

1. Хүлээн авагч улсад хүүхдийг шилжүүлсний дараа түүнийг үрчлэн авах эцэг эхийн хамт цаашид байлгахад хүүхдийн ашиг сонирхолд



нийцэхгүй гэдгийг эрх бүхий төв байгууллагад мэдэгдвэл тухайн байгууллага хүүхдийг хамгаалах арга хэмжээ авна:

(a) үрчлэн авах хүсэлт гаргасан эцэг эхээс хүүхдийг буцаан авч, түр асрамжид өгөх;

(b) хүүхдийн төрөлх улсын эрх бүхий төв байгууллагатай зөвшилцөн, хүүхдийг үрчлүүлэх үүднээс цаг алдалгүй шинээр шилжүүлэн суурьшуулах бөгөөд хэрэв энэ арга хэмжээ тохиромжгүй бол урт хугацааны асрамжид өгнө. Хүүхдийн төрсөн улсын эрх бүхий төв байгууллага үрчлэн авах шинэ эцэг эхийн талаар бүрэн мэдээлэл авах хүртэл хүүхдийг үрчлүүлэхгүй;

(c) хүүхдийн ашиг сонирхол шаардвал эцэст нь түүнийг буцаах арга хэмжээ авна;

2. Хүүхдийн нас, төлөвшлийг харгалзан түүнтэй зөвлөлдөх бөгөөд шаардлагатай тохиолдолд энэ зүйлийн дагуу авах арга хэмжээний хувьд зөвшөөрлийг нь авна.

22 дугаар зүйл

1. Энэхүү бүлэгт заасан эрх бүхий төв байгууллагын үүргийг төрийн байгууллагууд, эсхүл III хэсэгт заасны дагуу итгэмжлэгдсэн байгууллагууд тухайн улсын хуулиар зөвшөөрсөн хэмжээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж болно.

2. Хэлэлцэн тохирогч улсууд 15-аас 21 дэх зүйлийн дагуу эрх бүхий төв байгууллагын үүргийг тухайн улсад хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд эрх бүхий байгууллагын хяналтан дор дараахь байгууллага, итгэмжлэгдсэн этгээд гүйцэтгэж болохыг Конвенцийн хадгалагчид мэдэгдэж болно. Үүнд:

(a) шударга, мэргэжлийн өндөр чадвар, туршлага болон тухайн орны хариуцлагыг үүрэх шаардлагыг хангасан;

(b) улс хооронд хүүхэд үрчлэх хүрээнд ёс суртахуун, боловсролын болон ажлын туршлагатай.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар мэдэгдэл хийсэн хэлэлцэн тохирогч улс олон улсын хувийн эрх зүйн асуудлаар байгуулагдсан Гаагийн бага хурлын байнгын товчоонд эдгээр байгууллага, хүмүүсийн нэр, хаягийг мэдэгдэнэ.



4. Хэлэлцэн тохирогч аливаа улсын эрх бүхий төв байгууллага тухайн улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа хүүхдийг үрчлүүлж болох тухай мэдэгдлийг 1 дэх хэсэгт заасны дагуу Конвенцийн эх хадгалагч улсад мэдэгдэж болно.

5. 2 дахь хэсгийн дагуу гаргасан мэдэгдэл болон 15, 16 дугаар зүйлд заасан тайланг аливаа тохиолдолд 1 дэх хэсгийн дагуу эрх бүхий төв байгууллага буюу бусад байгууллага бэлтгэнэ.

V ХЭСЭГ

ҮРЧЛЭН АВАХЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

23 дугаар зүйл

1. Конвенцийн дагуу холбогдох улсын эрх бүхий байгууллага гэрчилсэн үрчлэлтийг хэлэлцэн тохирогч өөр нэг улсын хуулиар хүлээн зөвшөөрнө. 17 дугаар зүйлийн “с” дэд хэсгийн дагуу хэзээ, хэн зөвшөөрөл өгсөн тухай гэрчилгээнд тусгана.

2. Хэлэлцэн тохирогч улс бүр гарын үсэг зурсан, соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан, эсхүл нэгдэн орсон үедээ Конвенц хадгалагчид тухайн улсад гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагын үүргийг мэдэгдэнэ. Эдгээр эрх бүхий байгууллагын гүйцэтгэх үүрэгт өөрчлөлт орсон бол энэ тухай мэдэгдэнэ.

24 дүгээр зүйл

Үрчлэлт төрийн бодлогод илт харшилбал хэлэлцэн тохирогч улс хүүхдийн ашиг сонирхлын үүднээс үрчлэлтийг зөвшөөрөхгүй байж болно.

25 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч улс энэхүү Конвенцийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу байгуулсан хэлэлцээрийн үндсэн дээр явагдсан үрчлэлтийг хүлээн зөвшөөрөөгүй гэдгээ Конвенц хадгалагчид мэдэгдэнэ.

26 дугаар зүйл

1. Үрчлэлтийг хүлээн зөвшөөрнө гэдэгт доорх зөвшөөрлийг ойлгоно:

(a) хүүхэд болон үрчлэх эцэг эхийн хооронд эрх зүйн харилцаа үүссэн;

(b) хүүхдийн өмнөөс үрчлэн авах эцэг эхийн



хүлээх хариуцлага;

(с) хэрэв хэлэлцэн тохирогч улсад үрчлэлтээс үүсэх үр дагавар тийм байдаг бол хүүхэд болон түүний эцэг эхийн хооронд өмнө нь байсан харилцаа дуусгавар болно.

2. Эцэг эх, хүүхдийн хооронд урьд байсан эрх зүйн харилцаа дуусгавар болж байгаа үрчлэлтийн хувьд, хүлээн авагч болон үрчлэлтийг хүлээн зөвшөөрсөн бусад хэлэлцэн тохирогч улсад үрчлэлтийн ийм үр дагавраас үүдэн бий болдог эрхийг эдэлнэ.

3. Өмнөх хэсэгт үрчлэлтийг хүлээн зөвшөөрсөн хэлэлцэн тохирогч улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хүүхдэд ашигтай заалтыг хэрэглэхэд саад болохгүй.

27 дугаар зүйл

1. Хүүхэд төрсөн улсад явагдсан үрчлэлт нь эцэг эх, хүүхдийн хооронд байсан харилцааг дуусгавар болгох үр дагаваргүй бол үрчлэлтийг Конвенцийн дагуу хүлээн зөвшөөрсөн хүлээн авагч улсад дараахь эрх зүйн үр дагавар бүхий үрчлэлт гэж тооцогдож болно:

(а) хүлээн авагч улсын хуулиар зөвшөөрсөн бол;

(b) 4 дүгээр зүйлийн (с), (d) дэд хэсгүүдэд дурдсан зөвшөөрөл нь инхүү үрчлүүлэх зорилгоор олгодсон бол.

2. 23 дугаар зүйлийг үрчлэлтийн үр дагаврыг шилжүүлэн тогтоох шийдвэр гаргахад хэрэглэнэ.

ЕРӨНХИЙ ЗААЛТ

28 дугаар зүйл

Энэхүү Конвенц нь үрчлэлтийг зөвхөн хүүхдийн байнга оршин суух улсад явуулахыг заасан, эсхүл үрчлэлт явагдаж дуусахаас өмнө хүлээн авагч улсад хүүхдийг шилжүүлэхийг хориглосон болон төрөлх улсын хуулийн заалтыг хөндөхгүй.

29 дүгээр зүйл

Хүүхдийг түүний гэр бүлийн дотор үрчлүүлээгүй буюу хүүхдийн төрөлх улсын эрх бүхий байгууллагаас тогтоосон нөхцлийн дагуу холбоо харилцаа тогтоогоогүй бол үрчлэн авагч эцэг эх болон хүүхдийн эцэг эх буюу асран хамгаалагч бусад этгээд 4 дүгээр



зүйлийн (а)-аас (с) хүртэлх дэд хэсэг, мөн 5 дугаар зүйлийн (а) дэд хэсэгт заасан шаардлага хангагдах хүртэл харилцаатай байх ёсгүй.

30 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагууд хүүхдийн гарал, ялангуяа хүүхдийн эцэг эхийн танигдах мэдээлэл, эрүүл мэнд, өвчний түүхтэй холбоотой мэдээллийг хадгална.

2. Тэдгээр байгууллага нь хүүхэд буюу түүний төлөөлөгчийг дээрх мэдээллээр тухайн улсын хуулиар зөвшөөрсөн хэмжээнд зохих удирдамжийн дагуу хангана.

31 дүгээр зүйл

30 дугаар зүйлийн хэрэгжилтэд хохирол учруулахгүйгээр, Конвенцийн дагуу цуглуулсан буюу дамжуулсан хувийн мэдээлэл, ялангуяа 15, 16 дугаар зүйлд тусгагдсан мэдээллийг зөвхөн цуглуулах буюу дамжуулах зорилгоор ашиглана.

32 дугаар зүйл

1. Улс хооронд хүүхэд үрчлүүлэхтэй холбогдох явдлаас хэн ч санхүүгийн буюу бусад ашиг хонжоо олох ёсгүй.

2. Үрчлэх ажиллагаанд оролцсон мэргэжлийн хүмүүсийн хөлс болон бусад зардлыг нэхэмжлэх буюу төлж болно.

3. Үрчлэх ажиллагаанд оролцсон байгууллагуудын захирал, гүйцэтгэх ажилтнууд нь үзүүлсэн үйлчилгээтэй харьцуулахад бодит бус, өндөр хөлс, төлбөр авах ёсгүй.

33 дугаар зүйл

Конвенцийн аливаа заалтыг хүндэтгэн үзээгүй, эсхүл хүндэтгэхгүй байх ноцтой эрсдэл буй гэж эрх бүхий байгууллага үзвэл энэ тухайгаа өөрийн улсын эрх бүхий төв байгууллагад даруй мэдээлнэ. Энэхүү эрх бүхий төв байгууллага нь зохих арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

34 дүгээр зүйл

Баримт бичгийг хүлээн авах улсын эрх бүхий байгууллага эх хувьтай нь нийцсэнийг гэрчилсэн орчуулгаар хангана. Өөрөөр заагаагүй бол орчуулгын зардлыг үрчлэн

авах эцэг, эх хариуцна.

35 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд үрчлэлтийг шуурхай явуулна.

36 дугаар зүйл

Үрчлэлтийн харилцаанд хоёр буюу түүнээс дээш эрх зүйн тогтолцоо үйлчлэх улсын нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хувьд:

(а) тухайн улсад байнга оршин суух тухай заалтыг тухайн улсын нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суух хэмээн;

(b) тухайн улсын хуулийн тухай заалт нь тухайн улсын холбогдох нутаг дэвсгэрт дагаж мөрдөж байгаа хууль хэмээн;

(c) тухайн улсын эрх бүхий байгууллага, төрийн байгууллагын талаархи заалт нь холбогдох нутаг дэвсгэрийн нэгжид үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын талаархи заалт хэмээн;

(d) тухайн улсын итгэмжлэгдсэн байгууллагын талаархи заалт нь холбогдох нутаг, дэвсгэрийн нэгжид ажиллах итгэмжлэгдсэн байгууллагын талаархи заалт хэмээн ойлгоно.

37 дугаар зүйл

Янз бүрийн бүлэг хүмүүст үйлчлэх үрчлэлтийн харилцаанд үйлчлэх хоёр буюу түүнээс дээш эрх зүйн тогтолцоотой улсын хувьд тус улсын хуулийн талаархи аливаа заалт нь тухайн улсын хуулиар тодорхойлсон хуулийн тогтолцоонд хамаарна.

38 дугаар зүйл

Эрх зүйн нэгдмэл тогтолцоотой улс Конвенцийг дагаж мөрдөх үүрэг хүлээгээгүй бол үрчлэх асуудлаар өөрийн эрх зүйн журам бүхий нутаг дэвсгэрийн нэгжүүд Конвенцийг хэрэгжүүлэх үүрэг хүлээхгүй.

39 дүгээр зүйл

1. Тус Конвенцоор зохицуулсан асуудлаар зүйл, заалтыг агуулсан хэлэлцэн тохирогч улсуудын нэгдэн орсон олон улсын гэрээ, тэдгээр улсаас холбогдох мэдэгдэл хийгээгүй нөхцөлд энэхүү Конвенцийг хөндөхгүй.

2. Аливаа хэлэлцэн тохирогч улс Конвенцийн



хэрэглээг дээшлүүлэх зорилгоор нэг буюу түүнээс дээш хэлэлцэн тохирогч улстай харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд хэлэлцээр байгуулж болно. Эдгээр хэлэлцээр нь зөвхөн 14-өөс 16 болон 18-аас 21 дэх зүйлийг баримтлахгүй байж болно. Ийм хэлэлцээр байгуулсан улсууд хэлэлцээрийн нэг хувийг Конвенцийн мэдэгдлийг хүлээн авагчид хүргүүлнэ.

40 дүгээр зүйл

Энэхүү Конвенцид тайлбар хийхгүй.

41 дүгээр зүйл

14 дүгээр зүйлийн дагуу гаргасан өргөдлийг, хүлээн авагч улс болон хүүхэд төрсөн улсад Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хүлээн авсан бүх тохиолдолд энэхүү Конвенц үйлчилнэ.

42 дугаар зүйл

Олон улсын хувийн эрх зүйн асуудлаарх Гаагийн бага хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга нь Конвенцийн хэрэгжилтийг хянах зорилгоор тодорхой хугацаанд тусгай комисс хуралдуулж байна.

VI ХЭСЭГ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

43 дугаар зүйл

1. Олон улсын хувийн эрх зүйн асуудлаарх Гаагийн бага хурлын 17 дугаар чуулганы үед гишүүн байсан улсууд болон тус чуулганд оролцсон бусад улс гарын үсэг зурахад энэхүү Конвенц нээлттэй.

2. Конвенцийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл батласан тухай баримт бичгийг Конвенцийн талаархи мэдэгдэл хүлээн авагч болох Нидерландын Вант Улсын Гадаад хэргийн яаманд хадгалуулна.

44 дүгээр зүйл

1. Конвенц 46 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хүчин төгөлдөр болсны дараа аливаа бусад улс түүнд нэгдэн орж болно.

2. Нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хадгалагчид хадгалуулна.

3. Ингэж нэгдэн орох нь Конвенцийн 48 дугаар зүйлийн “b” дэд хэсэгт дурдсан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6 сарын дотор, хэлэлцэн тохирогч улс хоорондын



харилцаанд хамаарна. Нэгдэн орсны дараа энэхүү Конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах үед улсууд мөнхүү эсэргүүцэл үзүүлж болно. Аливаа ийм эсэргүүцлийн талаар гэрээ хадгалагчид мэдэгднэ.

45 дугаар зүйл

1. Хэрэв тухайн улс энэхүү Конвенцтой холбоотой асуудлаар эрх зүйн өөр тогтолцоо бүхий хоёр, түүнээс дээш нутаг дэвсгэрийн нэгжтэй бол гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрсөн, батлах, эсхүл нэгдэн орох үедээ тус улс нь энэхүү Конвенцийг өөрийн нутаг дэвсгэрийн бүх нэгжүүд, эсхүл нэг ба түүнээс илүү нэгжид хэрэглэх тухайгаа мэдэгдэж болох бөгөөд, энэ мэдэгдлээ хэдийд ч өөр мэдэгдэл гарган өөрчилж болно.

2. Аливаа ийм мэдэгдлийн талаар гэрээ хадгалагчид мэдэгдэх ёстой бөгөөд энэхүү Конвенцийг дагаж мөрдөх нутаг дэвсгэрийн нэгжүүдийг тодорхой заана.

3. Хэрэв тухайн улс энэ зүйлийн дагуу мэдэгдэл гаргаагүй бол энэхүү Конвенц тухайн улсын нутаг дэвсгэрийн бүх нэгжүүдэд үйлчилнэ.

46 дугаар зүйл

1. Энэхүү Конвенц нь 43 дугаар зүйлийн дагуу соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл батласан гурав дахь баримт бичгийг хадгалуулснаас хойш гурван сарын хугацаа өнгөрмөгц дараагийн сарын эхний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Ингэснээр Конвенц нь:

(а) түүнийг соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон улсын хувьд соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш гурван сарын хугацаа өнгөрмөгц дараагийн сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

(б) 45 дугаар зүйлийн дагуу Конвенц үйлчилж байгаа нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд дээрх зүйлд дурдсан мэдэгдэл гарснаас хойш гурван сарын хугацаа өнгөрмөгц дараагийн сарын эхний өдрөөс

хүчин төгөлдөр үйлчилнэ.

47 дугаар зүйл

1. Конвенцийн гишүүн улс гэрээ хадгалагчид бичгээр мэдэгдэл гарган түүнийг цуцалж болно.

2. Мэдэгдлийг гэрээ хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш арван хоёр сарын хугацаа өнгөрмөгц дараагийн сарын эхний өдрөөс эхлэн Конвенцийг цуцална. Мэдэгдэлдээ Конвенцийг цуцлах удаан хугацаа тогтоосон бол гэрээ хадгалагч мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш мөнхүү хугацаа дууссаны дараа цуцална.

48 дугаар зүйл

Гэрээ хадгалагч олон улсын хувийн эрх зүйн асуудлаарх Гаагийн бага хурлын гишүүн улсууд, арвандолдугаар чуулганд оролцсон бусад улс болон 44 дүгээр зүйлийн дагуу нэгдэн орсон улсуудад доорх мэдээллийг өгнө:

(a) 43 дугаар зүйлд дурдсан гарын үсэг зурсан, соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, батласан тухай;

(b) нэгдэн орсон болон 44 дүгээр зүйлд дурдсаны дагуу нэгдэн ороход эсэргүүцсэн тухай;

(c) 46 дугаар зүйлийн дагуу Конвенцийн хүчин төгөлдөр болсон он, сар, өдөр;

(d) 22, 23, 25, ба 45 дугаар зүйлүүдэд дурдсан мэдэгдэл, томилолтын тухай;

(e) 39 дүгээр зүйлд дурдсан хэлэлцээрийн тухай;

(f) 47 дугаар зүйлд дурдсан хүчингүй болгох тухай.

Үүнийг нотолж, өөрсдийн засгийн газраас зохих бүрэн эрх олгогдсоны дагуу энэхүү Конвенцид гарын үсэг зурав.

1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Гааг хотноо англи, франц хэлээр тус бүр нэг хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Эх бичвэрийг Нидерландын Вант Улсын Засгийн газрын архивт хадгалах бөгөөд нэг хувийг баталгаажуулж арван долдугаар чуулганы үед олон улсын хувийн эрх зүйн асуудлаар байгуулагдсан Гаагийн бага хурлын гишүүн улсуудад болон уг

чуулганд оролцсон улс бүрт илгээнэ.